

# МОНГОЛ ДАХЬ ШАШНЫ БОЛОВСРОЛЫН ТӨЛӨВ БАЙДАЛ

*М. Саранцэцэг*

*Доктор (Ph. D.), дэд профессор*

*Монгол улсын боловсролын их сургууль. Нийгэм, хүмүүнлэгийн сургууль*

saraa\_myunga@yahoo.com

**Abstract:** Due to the rapid development of science, information and technology, the lifestyle of mankind has changed and technocrats have dominated. There is a global problem that needs human development, lack of humanity, and humanity. Even in our country, educational trends are in the process of raising awareness and living standards. This has led to a certain level of development in the country, but there is a lack of it. For example, the traditional way of life of the Mongolian Buddhists is still missing. Therefore, in this article, we address religious education issues.

**Keywords:** Education, religious attitudes, government policies and calls

## УДИРТГАЛ ХЭСЭГ

Өөрчлөгдөн буй нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн манай улс боловсролыг олон улсын жишигт ойлтуулах чиглэлээр бүх шатны сургалтын хөтөлбөрүүдэд шинэчлэл хийж байна. Ер нь боловсрол бол хүний орших арга, хүн төрөлхтөний түүх, соёлд хуримтлагдсан арга, туршлагыг өөриймшүүлэх, үргэлжлүүлэх үйл явц юм. Мэдээлэл, технологийн хөгжлийн хурдастай хөл нийлүүлэн сургалт нь суралцагсдад шинэ бололцоо, өөрийгөө нээн илэрхийлэх боломж мөн үндэсний хийгээд хүн төрөлхтөний үнэт зүйлийг өөриймшүүлэх арга болон хувирч байгаа нь сайшаалтай боловч нөгөө талаараа хүний эрхэм чанар, түүний үнэ цэнэтэй талыг орхигдуулж ирсэн нь орчин үеийн боловсролын өрөөсгөл байдалтай холбоотой болохыг дэлхий нийтээр ойлгож эхэлсэн. Иймд “... хүмүүсийн оюун ухаан ба сэтгэлийн шинжлэх ухаанжуулахаас дутуугүйгээр хүмүүнжүүлэх шаардлага нийгэмд тулгарч байна” [1.6].

## ОНОЛ, АРГА ЗҮЙН ХЭСЭГ

Шашны боловсрол олгох үйл явц манай орны хувьд хэрхэн, ямар түвшинд явагдаж байна вэ?

XIII-XIV зуун Их Монгол Улсын үед төрийн бодлогын гол зорилт нь “Биенийг нь эзэлтэл сэтгэлийг нь эзлэгтүн. Сэтгэлийг нь эзэлвээс бие нь хаа одох” гэсэн Чингисийн билиг сургаалд зангидагдаж байсан. Үүний гол илрэл нь “... эзлэгдэн дагасан ард түмэн бүхэн өөр өөрийн шашин

суртахуунаа хуучин хэвээр дагаж мөрдөх эрхтэй хэмээн тэр бүх шашинд хүлцэнгүй хандах явдал” [2.40] энэ үеийн монгол төрийн бодлогын гол зарчим байв.

“Манжийн эрхшээлийн үеийн монгол оронд олон зуун жил уламжлагдаж ирсэн гэрээр /манж хэл, тоо бодлого, монгол хэл, шашны ном/ боловсрол олгох, мөн шинээр нилээд хүчтэй дэлгэрэн өргөжөөд байсан шашны /буддын сургаал/ гэсэн сургалтын үндсэн 2 хэлбэр байжээ” [3.305]. Мөн “Монгол түмнийг, тухайлбаас монгол хүүхдийн хүмүүжил соёлд оюун билиг, ухамсар, сэтгэлгээний зан төлөв төлөвшин хөгжихөд нүүдлийн ахуй, аж төрөх ёс, тэр дундаа бөө мөргөлийн зэрэгцээ гол үзэл суртахуун болсоор ирсэн бурхны шашин, буддын соёл чухал үүрэгтэй байсныг үгүйсгэж болохгүй юм” [4.213] гэснийг дүгнэн харвал шашны боловсрол бидний хувьд саяхны ойлголт бус харин бүр эртний улбаатайг илтгэж байна.

1921 оны ардын хувьсгал монгол оронд нийгэм-улс төр, эдийн засаг, соёлын хүрээнд эрс өөрчлөлт, шинэ үзэл санаа бэхжин тэлэх нөхцлийг бүрдүүлж өгсөн. 1924 онд анхны үндсэн хуулийг батлахын зэрэгцээ, шашин-төрийн тэргүүн Богд хааны төрийн эрхийг шууд бус зугуухан халах бодлогыг явуулснаар шашны боловсролын уламжлалт ойлголт үндсэндээ хязгаарлагдмал байдалд орсон. Улмаар 1926 онд “Тус улсын төр шашны хэргийг тусгаарлан явуулах тухай хууль” [5.274] батлаж, уг хуулийн 9 зүйлд “Их хүрээний газраа тусгай шашны хэргийг эрхлэх газар байгуулж тус хүрээ Гандангийн аливаа шашин номын хэргийг эрхлүүлбээс зохимой” [5.275] хэмээснээр шашны боловсролыг төрөөс албан ёсоор тусгаарлаж гагцхүү шашны байгуулга болох Гандан хүрээнд гүйцэлдүүлэхээр болсон.

Ингэж монголд шашингүй үзэл ноёрхож эхлэх үүд хаалгыг нээснээр монголын төр ч шашингүй, ард иргэд нь ч итгэх, сэтгэлээ тайвшруулах бишрэлгүй биегүй хувцас лугаа болсон. Боловсролын бүх салбарт атейзм ноёлов.

Дээд боловсролын системд гарсан өөрчлөлт юуг илтгэв.

1963 онд Намын Төв Хорооноос зохион байгуулсан “Нийгмийн ухааны багш нарын улсын зөвлөгөөн”, “Тэргүүний ухуулагч, суртал нэвтрүүлэгчдийн улсын зөвлөгөөн”-ий шийдвэрийн үндсэн дээр “Их дээд сургуулиудад марксист-ленинист философийн зэрэгцээ ёс зүй, гоо зүй, шинжлэх ухааны шашингүй үзлийг заах болсон [6.206]. Энэ нь хэдийгээр нэг үзэл суртал, нэг намын албан ёсны сургалтыг хуульчилсан боловч нөгөө талаараа оюутан залуучуудын сэтгэлгээг төлөвшүүлэх, улмаар тэдний оюуны соёлын түвшинг дээшлүүлэх нэг нөхцөл болсон. 1992 онд Дээд дунд боловсролын хорооноос “Нийгмийн ухааны сургалтыг шинэчлэх асуудал”-аар их дээд сургуулиудын нийгмийн ухааны тэнхимийн эрхлэгч

нарын семинар зохион байгуулж, улмаар “Үзэл суртлын шинжтэй зарим хичээлүүдийг сурталтын төлөвлөгөөнөөс хасах санал тавигдан, сургалтын цөм праграмм зохиох болсон [6.206]. Энэхүү семинарын үр дүнд “Шинжлэх ухааны шашингүйн онол хичээлийг “Шашны түүх ба онол” нэртэй болгон өөрчлөж, заах агуулгыг орчин үеийн сэтгэлгээнд хүргэх зорилт тавьсан юм [6.208]. Ингэснээр олон ургалч үзлийн үүднээс шашинд хандах, шашин суртахууны онол сургаалийг дан ганц марксист-ленинист үзлийн үүднээс хандах үндслэлийг аль болохоор багасгах оролдлогыг хийсэн юм. 1992 онд шинэ үндсэн хууль, 1993 онд “Төр сүм хийдийн харилцааны хууль” батлагдсан нь шашинд хандах хүн амын сэтгэлгээ шинэчлэгдэх нөхцлийг бүрдүүлж, улмаар нэг үзэл суртлаар хэмжигдэх сургалтыг бусдаас дээгүүр тавьдаг практикийг халж, хүмүүсийн итгэл үнэмшил болсон аливаа сургаалийг заан сургах эрх зүйн үндсийг бүрдүүлж өгсөн юм.

Хэдийгээр их дээд боловсролын системд тодорхой өөрчлөлт орж байсан боловч дунд боловсролын хүрээнд дорвитой өөрчлөлт гараагүй юм. Энэ байдал өнөөг хүртэл оршоор л байна. Өнөөгийн нийгмийн сэтгэлгээ хийгээд оюун санааны амьдрал дахь шинэчлэлийн үйл явц сургалтын системийг бүхлээр нь өөрчлөн шинэчлэх гарцаагүй байдалд хүргэсэн. Өөрөөр хэлбэл, ирээдүй хойч үе болсон хүүхэд залуучууд юунд итгэж найдах вэ? гэдэг нь нэн чухал асуудал болоод байна. Бид бүхний харж байгаагчлан шашны боловсролын хүрээнээс энэхүү асуудлын хариуг олох боломжтой юм. Дашрамд дурдахад, түүхийн явцад шашин эерэг, сөрөг янз бүрээр л үнэлэгдэж ирсэн. Энэ бол шашны боловсролтой холбоотой бөгөөд зарим тохиолдолд төөрөгдөл, алдаа, зориудын гуйвуулга ч байсан.

Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого /2014-2024он/ [7], 2016 онд батлагдсан бага, дунд боловсролын тухай хууль [8], 2012-2016 онд Засгийн газраас хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө [9], “Зөв монгол хүүхэд” үндэсний хөтөлбөр, “Хүүхэд бүрийг хөгжүүлэх, тэдний ахиц амжилтыг дэмжих” сургалтын хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх, “Эрдэм боловсролтой монгол хүн” гэх мэт хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж эхэлсэн. Энэ бүгдээс харахад эдгээр баримт бичиг суралцагчдын мэдлэг чадвар хандлага төлөвшлийн асуудал дээр гол анхаарлаа төвлөрүүлжээ. Гэсэн хэдий ч энэхүү боловсролын шинэчилсэн хөтөлбөр сураглцагчдын хүн байх, хүний нинжин сэтгэл, тусч чанар, өгөөмөр зангийн тухай дурдаагүй бөгөөд нөгөө л технократ хүнийг төлөвшүүлэх асуудлыг тусгасан байна. Францын аялагч Гюкийн тэмдэглэлд “Сайн монгол хүн бол шашны гүнзгий мэдрэмжтэй байдаг [10] хэмээсэнчлэн бид өнөөгийн боловсролын зорилгод сайн монгол хүний асуудал ярьж буй үед шашны боловсролын тухай асуудлыг хөндөхөөс өөр ч замгүй юм. Гэтэл дээрхи дурдсан хөтөлбөрүүдийн хэрэгжилтэнд “Сайн монгол хүн”-ий гол шинж

болсон шашны боловсролын асуудал хэрхэн туссан бол. Тухайлбал, ЕБС-д шашны тухай 6-9, 10-12 ангиудад “Иргэн ба нийгэм”, “Нийгмийн ухаан”-ны хичээлүүдээр зааж буй боловч энэ нь зөвхөн христос ислам, буддын шашны талаар танилцах төдийхнөөр хязгаарлаж буй нь бусад шашны талаархи ойлголт хангалтгүй, цаашилвал, шашны боловсролын мэдлэг нимгэн байх нэг үндэслэл болсоор байна.

Хүмүүнлэгийн шинжлэх ухааны нэгэн том салбар бол яахын аргагүй шашин. Тэгвэл бид шашны боловсролоор дамжуулж тэрхүү шашинг танин мэдэж, шашны мэдлэгийг хуримтлуулж байдаг. Шашны боловсрол бол хүмүүнлэгийн ухааны сургалтын зөвхөн нэг л хэлбэр нь юм. Иймд энэ хандлагаар хүүхэд залуучуудыг нэгдмэл оюун санаагаар хүмүүжүүлэн төлөвшүүлэх ихээхэн ач холбогдолтой юм. Хүн соёлоор дамжуулан бодит байдлыг танин мэдэж, оюуны соёлын үнэт зүйлийг эзэмшиж, өөртөө хүртээлтэй болж, бие хүн болон төлөвшдөг.

Шашны боловсролыг олгож буй байдлаас шалтгаалан магадгүй зарим иргэд шашин, ёс суртахуун хүн байх үндэс нь атал түүнийг үгүйсгэн харин шинжлэх ухааны мэдлэгийг эзэмших, дээд боловсрол олж авах гэх мэтчилэн ойлгож байж болох талтай. Харамсалтай нь тэр иргэдийн ойлгодогчлон энэ мэдлэг хүнийг хүн болгочихгүй нь мэдээжийн хэрэг.

Философич Ц.Гомбосүрэн “... сургалтыг шинжлэх ухаанжуулах тухай их ярьдаг боллоо. Хэрэв ийм зорилтыг бодит ажил болговол зөвхөн байгалин шинжлэл, техникийн мэдлэгтэй, харин хүмүүнлэгийн мэдлэгийн гуйланчлалд автсан, тэгээд алсдаа технократ сэтгэлгээнд ба сэтгэлд ноёлуулсан боловсон хүчин улс орныг авч явах болох нь” [1.14] гэж дурдсанаараа өнөөгийн нийгэмд хүмүүнлэгийн шинжлэх ухааны мэдлэг тэр тусмаа шашны боловсрол зайлшгүйг онцлон тэмдэглэжээ.

Өнөө үед оюун санааны хүрээнд шашны нөлөө онцгой их анхаарал татаж байна. Учир юун хэмээвээс олон түмний дунд төдийгүй судлаач эрдэмтдийн дотор шашны олон урсгал байх нь зөв мэт ойлголт төсөөлөл тодорхой хэмжээгээр буй болж, хэвшин хэрэглэгдэх төлөвтэй болжээ. Гэтэл чухамдаа тийм олон шашин үнэхээр байна уу? Үгүй юу яагаад гэдэг асуулт зүй ёсоор гардаг. 2017 онд явуулсан судалгаагаар: “Монголын нийт хүн амын % нь шашин шүтдэг. Түүнээс буддын шашин 49 %, христосын шашин 39 %, исламын шашин 9 %, Бөөгийн шашин 2%, бусад 1 % байна” [11] гэсэн судалгааны дүн гарчээ. Түүнчлэн хүмүүсийн шашинд хандах байдал нь гүн сүсэгтэн 16%, жирийн сүсэгтэн 27%, хэлбэлзэгч сүсэгтэн 38, шашны байр суурьтай хүмүүс 8%, тууштай шашингүй үзэлтэй хүмүүс 11% байна. Энэ байдлыг Д.Урианхай “Монголчууд бид ертөнцийг үзэх өөрийн үндэсний гүн ухааны тогтолцоогүй, түүнээсээ болоод сэтгэлгээний хувьд “тусгаар тогтнол”-оо олоогүй, түүхийнхээ бүх цаг үеийн турш харийн сэтгэлгээний дуулгавартай боол, гадаадын сэтгэгчдийн

“номхон шавь болж явсаар ирсэн явдал” [12.132] хэмээснээрээ өнөөгийн шашны өнгө төрхийг илэрхийлсэн мэт.

Энэхүү судалгааг төрийн бодлоготой хэрхэн уялдуулах вэ?

Монголчуудын хувьд үеийн үед шашны асуудал нэн чухал байсан. Ялангуяа төр шашны харилцааны асуудалд ихээхэн анхаарал хандуулж ирсэн түүхтэй. XIII зуунаас хойш шашин төрийг хослон барих бодлого нь “ном” гэсэн ойлголтыг агуулж ирсэн байдаг. Энэ бодлого нь “Төрийн хатуу үйлийг шашны номоор зөөллөнө гэсэн үг [13]. Гэтэл өнөөгийн төрд шашны талаархи үзэл, хандлагуудыг ойлголцолд хүргэх, нийцтэй болгох бололцоог эрж олох, мэргэжлийн судлаачид болон эрдэмтдийн санаа бодлыг сонсож байх, чадвар юуны өмнө дутагдаж байна. Энд бид дэлгэрэнгүй үндэслэл үл өгүүлэн ганцхан жишээг дурдвал, Францын хааны элч, хар лам Рубрук Мөнх хааны захидлыг францын хаанд хүргэхээр буцах болж, салах ёсны уулзалт хийхээр Мөнх хаанд бараалхахдаа: “Ертөнцийн эзний номоор амь зуухыг хүнд сургах нь бидний үүрэг болой. Ийм ч чигийг барь бид эл газар ирсэн” гэж Монгол газар ирсэн зорилгоо тодорхойлоод, “хэрвээ Таны соёрхолд нийцэх аваас энд дуртайяа үлдэхсэн, эсхүл таны захидал бичгийг хүргэсний дараа танай нутагт эргэн ирэхийг минь соёрхон зөвшөөрөхийг хүсэж буй” гэснээр Христосын шашныг монгол газар суртчлан дэлгэрүүлэх зөвшөөрлийг хүсэхэд Мөнх хаан дуугаа хураан удтал бодолхийлэн сууснаа “Чи холын замд гарах хүн, эртхэн явж юм хумаа базаа” [14.26] хэмээн уулзалтыг дуусгасан тухайгаа тэмдэглэн үлдээсэн байдаг. Эндээс үзвэл, эзлэгдэн дагасан ард түмэн бүхэн өөр өөрийн шашин мөргөлөө даган шүтэх эрхтэй ч асуудал монгол төрийн түвшинд яригдсан үед байдал арай өөр болж байна. Өөрөөр хэлбэл төрийн зүгээс бүх шашинг үл ялгаварлах зарчим баримтлах авч шинээр орж ирэх гэж буй шашинд төрийн бодлогоор хандаж байжээ. Энэ зарчим шашны боловсролын үнэ цэнэ, уламжлалт сэтгэлгээний өвийг бэхжүүлж байсан шашны талаархи төрийн бодлого мөн.

Харамсалтай нь түүхийн нугачаанд энэхүү бодлого бүдгэрч шашны боловсрол, шашны мэдлэг нь монголын ард түмний зөвхөн нууцхан, нандин үнэт зүйл болсон. “Шашин мөргөл дор болж үүний улмаас олон мянган өрх айл хил даван бусдын нутагт халин одсон, бурангуй дэглэмээс зайлсхийх явдал байсан юм [15.25]. Мөн нэгэн үе шашинг бид мухар сүсэг хэмээн ойлгож, шашин руу дайрах бодлого баримтлаж байлаа. Улс төрийн болон үзэл суртлын зорилгынхоо үүднээс үгүйсгэж, тэр бүү хэл шашны өндөр мэдлэг бүхий лам хуврагийг хавчин гадуурхаж, залхаан цээрлүүлж, заримыг нь бүр хөнөөсөн үйлдэл тун саяхных билээ.

Өнөө үед ч энэ ойлголт зарим тохиолдолд ул мөрөө үлдээсээр л байна. Тухайлбал, “... эзотерик мэдлэгийг, түүний дотор бөө мөргөлийн үйлдэл, шашин зэргийг мунхруулга төдийгөөр ойлгож, суртчилагч нар

цөөнгүй байдаг [1.14] мөн “... өнөөгийн хөгжлийн шатанд бурхны шашны нийгмийн амьдралд үзүүлэх нөлөөг түүхэн судалгааны хүрээгээр бараг хязгаарлагдаж ...”[16.83] байгаа явдал нь буддын шашны шинжлэх ухаанч шинжийг үгүйсгэх түүнчлэн бусдын шашинг дорд үзэх хандлага байгааг илтгэж байна. Монголын тухайн үеийн нийгмийн үзэл суртчилсан байдал нь шашныг шинжлэх ухааны нэр барин гуйвуулж ингэхдээ хүний хамгийн ойр байх сүсэг бишрэлийг нь ашигласан явдал юм.

Бид бүхний ирээдүй болсон хүүхэд залуучуудын шашны боловсрол дутмаг байгаагаас шалтгаалж аливаа шашны гаж нөлөөг эс ойлгон түүнийг сонирхон тэмүүлж, зөвхөн аль нэг талыг нь дөвийлгөн ойлгож улмаар уламжлалт сэтгэлгээгээ үл ойшоож байгаа нь харамсмаар. Энэ тухай шашин судлаач М.Гантуяа “Монголчуудын оюун санааны дархлаа алдагдаж, үндэсний задралд хүргэхэд ойрхон байна [13] хэмээн өгүүлсэн нь анхааруулга, сануулга мэт. Иймд бид улс үндэснийхээ сэтгэлгээний нэгдмэл байдлыг алдахгүй байх нь чухал юм. Түүнчлэн социологич С.Гомбо “Шашин шүтэх үү, шүтэхгүй байх уу гэдэг бол тухайн хүний хувийн чөлөөт сонголтын хэрэг боловч олон шашныг төрөөс сул тавьж болохгүй, олон шашинг нэгтгэхгүй ч буддын шашныг дэмжих бодлого нь үндэстний эв нэгдэлд хэрэгтэй бодлолго” [2.230] гэж шашнаар дамжуулан нийгэмд тогтвортой бодлого баримтлахын чухлыг онцлосон.

Иймд шашны асуудлын талаар төрийн хэрэгжүүлж буй бодлогыг эргэн харах нь зүйтэй болов уу. Эх сурвалжаас дүгнэн харвал, монгол төрийн мандал, буурлын аль ч үед шашны асуудал төрийн бодлогод нэн чухал байсныг проф Г.Лувсанцэрэн “... нийт нийгмийг оюуны хувьд нь нэгтгэн нягтруулах, үндэсний өвөрмөц дүр төрх, оюуны тусгаар тогтнолоо хадгалан бэхжүүлэх нэгэн гол хүчин болох хувьд нь шашны асуудлыг авч үздэг байжээ [2.51] хэмээн онцлон дурджээ.

Аливаа үндэсний соёл бол тухайн үндэстнийхээ оршин амьдрах эрмэлзлэлийг илэрхийлсэн утга, бэлгэдлийн тогтолцоо юм. Манай улс орон 1990 оноос эхлэн уламжлалт шашин соёлоо хүндэтгэн үзэх, шүтэх, уламжлалт ёс журмаа сэргээж эхэлсэн. Харамсалтай нь энэхүү үйл явц мэдээллийн өргөн солилцоо, шашин соёлын чөлөөтэй урсгал болсон даяаршлын эрин үетэй давхцаж байгаа нь бидний дөнгөж сэргэж буй уламжлалт соёлд сөргөөр нөлөөлөх хүчин зүйл болсон. 1992 оны шинэ үндсэн хуулинд “Төр нь шашнаа хүндэтгэж, шашин нь төрөө дээдлэнэ” гэж заасан боловч үнэн хэрэг дээрээ шашны асуудлын талаар ямар бодлого боловсруулж ажилласан бэ гэдэг нь өнөөдөр асуудал болоод байна. Түүний илрэл өмнө дурдсан тоон судалгаа юм. Судалгаа авах нэг хэрэг харин түүнийг бодлого болгон боловсруулах нь чухал хэрэг. Юуны өмнө төрөөс шашныг зохицуулах бодлогыг дахин боловсруулж хэрэгжүүлэх шаардлага тулгарч байна. Хуучин системийн гэж нэрлэгдэж

байсан /соц орнууд. М.С/ орнуудад “ ... уламжлалт бус шашнуудад тодорхой хязгаарлалт байхын зэрэгцээ хүн амын зүгээс эдгээр шашинд сэжиглэн цэрвэсэн хандлага илрэх нь цөөнгүй байх ажээ”[2.61] хэмээн шашин судлаач О.Чимэгийн судалгаанд дурдагдсан байна. Шашны гол үүрэг нь “нэгтгэгч” өөрөөр хэлбэл францын социологич Э.Дюркгейм “Шашин нийгмийн бүтцийг тусгах төдийгүй сүсэг бишрэлийнх нь нийтлэг буюу шүтлэгийн нь объектод тулгуурлан хүмүүсийн анхаарал, итгэл найдвараар нь нэгтгэж, ингэснээр нийгмийг тогтворжуулан бэхжүүлдэг” [17.453] гэж шашны чиг үүргийг тодорхойлсон байдаг.

Өнөө үед шашны боловсролд суралцах нь зайлшгүй чухал, бас хэрэгтэй гэдгийг нийгэмд гарч буй элдэв муу муухай үзэгдлүүд ойлгуулсаар байна. Гэтэл манай нийгмийн хувьд төрийн болон төрийн бус байгуулгаас явуулж буй шашны боловсролын үйл ажиллагаа нь ямар ч эмх замбараагүй, хоорондын холбоогүй тус тусдаа байгаа нь шашны талаар төрийн зохицуулалтын бодлого хомс байгаагийн илрэл гэж үзэх нь зүйд нийцэх болов уу.

## **ДҮГНЭЛТ**

Шашны боловсролыг эзэмшсэнээр хүний оршихуйн тухай, амьдралын утга учир, ёс суртахууны төлөвшилд маш чухал ач холбогдолтой. Тийм ч учир Монголчууд эртнээс нааш шашнаар дамжуулан хүмүүжүүлэх, ёс суртахууны чиг хандлага бий болгож ирсэн. Өөрөөр хэлбэл, яагаад монголчууд голын усанд бохир зүйл хийж болохгүй тухай ойлголтыг шашнаар дамжуулан итгэл үнэмшилээр бий болгож ирсэн уламжлалтай ард түмэн. Ийм учир шашны боловсрол өнөөгийн ялангуяа энэ цаг үед нэн чухал юм.

Шашны боловсролын өнөөгийн шаардлага нь тухайн үед “... хүний оюун санаа, сэтгэл зүйд байр сууриа улам бүр бэхжүүлж байгаа олон шашны аюул занал тун ойрхон байгааг өнөөгийн нөхцөл байдал сануулсаар байна [10.54] хэмээн өвгөн профессор Г.Гувсанцэрэн багш онцлож байсан нь магадгүй өнөөгийн мэргэжлийн судлаачид болон эрдэмтэд түүнчлэн төрийн төлөөлөлийн хамтын ажиллагаа чухал болохыг сануулж буй дуудлага байж болно.

## **НОМ ЗҮЙ**

[1] Ц.Гомбосүрэн. Б.Дагзмаа. Орчин үеийн монгол дахь түүхийн бүтээлүүдэд болон түүхэн романуудад Өндөр гэгээн Занабазарт өгсөн үнэлгээнд холбогдох философи тайлбар. УБ. 2016.

[2] Шашин шүтэх, эс шүтэх эрх, эрх чөлөө. УБ. 2004

[3] БНМАУ-ын түүх. 2 УБ. 1969.

- [4] Д.Дашбадрах. Үндэсний сурган хүмүүжүүлэхүйн уламжлалд холбогдох зарим тэмдэглэл. УБ. 2001.
- [5] Монгол Ардын Хувьгалт Намын түүхэнд холбогдох баримт бичгүүд. УБ.1966
- [6] Д.Давгадорж. Их дээд сургуулиудад шашин судлал хичээлийг заах арга зүйн асуудалд. УБ. 2001.
- [7] Монгол Улсын ИХ хурал.(2008). Монгол улсын мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого. 12-р тогтоол. УБ
- [8] Монгол Улсын ИХ хурал.(2016). Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030. 19-р тогтоол. УБ.
- [9] Монгол Улсын ИХ хурал.(2015). Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого. 12-р тогтоол. УБ.
- [10] Д.Мөнхжаргал. Монголчуудын уламжлалт сэтгэлгээ ба тогтвортой хөгжилд хөтлөхүйц багш боловсрол. Тогтвортой хөгжлийн боловсрол олон улсын хурлын илтгэл. УБ. 2015
- [11] Монгол сүсэгтний өнөөгийн зураглал. ШУА-ийн философийн хүрээлэн. УБ. 2017.
- [12] Д.Урианхайн “Бодь сэтгэл, эв хамт ёс”-Ганцаарчилсан хөдөлгөөний улс төрийн үзэл онолын “”Очир”-“Үнэнээс цогцолсон Зэндмэнэ” хэмээх номын тухай философийн шүүмж захидал. УБ. 2001.
- [13] М.Гантуяа. Улиудуг.mn6 2018.12.03
- [14] Гильом де Рубрук. Дорно этгээдэд зорчсон минь. УБ. 1988
- [15] Д.Хүүхэнбаатар. 1932-1933 оны Монголын дүрвэн гарах хөдөлгөөний тухай .УБ. 2001.
- [16] Д.Давгадорж. Монголын түүхэнд бурхны шашны үзүүлсэн нөлөө, нийгмийн төрх. УБ. 2004. 83 дахь тал
- [17] Н.Смелзер. Социологи. УБ. 2001.